



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,
Утас: 26-24-80, Факс: 263727

И-мэйл: info@mes.gov.mn, Веб сайт: www.mes.gov.mn

2020. 10. 22 № А/2361
танай 2020. 10. 08-ны № 24 -Т

Асуулгад хариу хүргүүлэх тухай

Таны 2020 оны 24 тоот албан бичгээр ирүүлсэн асуулгад дараах хариуг хүргүүлж байна.

Нэг. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын сургуулиуд хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж мөрдөж ажиллаж байгаа эсэх талаар

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасны дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/476 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь Хүүхэд хамгааллын бодлого”-ыг баталсан.

Бодлого нь сургууль, холбогдох байгууллага, иргэний нийгмийн болон салбар, мэргэжлийн холбоодын хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар суралцагчийг аливаа хүчирхийлэл, дарамт, дээрэлхэл, үл хайхрах байдал, болзошгүй эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тэдгээрт чиглэсэн хариу үйлчилгээ үзүүлэх чадавхыг нэмэгдүүлэх, сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэгдсэн.

2020 оны эхний хагас жилд ерөнхий боловсролын сургуулийн орчин дахь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хийсэн судалгааны үр дүнгээс харвал нийт ерөнхий боловсролын сургуулийн 61,2% нь хүүхэд хамгааллын бодлогоо шинэчлэн боловсруулж, батлуулсан байна.

Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж, гарын авлага боловсруулан нийт ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлсэн бөгөөд захирал, нийгмийн ажилтан, сургуулийн хүүхэд хамгааллын багийг чадавхжуулах сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулаад байна.

Хоёр. Сурагчид эрсдэлт нөхцөлд байгаа эсэхийг үнэлж, тэдгээрт хэрэгцээтэй зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх үүргээ хэрэгжүүлж байгаа эсэх талаарх мэдээлэл

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/239 дүгээр тушаалаар “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” журам, А/612 дугаар тушаалаар “Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах” журам-ыг тус тус баталж, мөрдөн ажиллаж байна.

“Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх” журамд заасны дагуу сургууль, дотуур байрын үйл ажиллагаа, гадаад болон дотоод орчинд хүүхдэд учирч болзошгүй нөхцөл байдал, эрсдэлийн үнэлгээг жил бүр хүүхэд хамгааллын баг хийж байна.

Үнэлгээнд суурилан эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн арга хэмжээ авах, хүүхдийн бэртэл гэмтэл, сэтгэл санааны байдал, айдас, хичээл таслалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, тандан судлах, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэдтэй ажиллах үйл ажиллагааны төлөвлөлт гарган ажиллах талаар тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт болон Боловсролын хүрээлэн, Насан туршийн боловсролын үндэсний төвөөс зохион байгуулж буй бүх сургалт, зөвлөн туслах ажлын агуулга, хөтөлбөрт хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг аргын арга зүйг тусган, багш нарыг ажлын байран дээр нь тасралтгүй чадавхжуулах, ур чадварыг нь дээшлүүлэх боломжийг олгох зорилгоор харъяа байгууллагын арга зүйч, холбогдох эрдэм шинжилгээний ажилтнуудыг “Хүмүүжлийн эерэг арга” сургагч багшаар бэлтгэлээ.

Түүнчлэн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтын нээлттэй онлайн курст “Хүмүүжлийн эерэг арга” платформ үүсгэж, холбогдох сургалтын материал, хэрэглэгдэхүүнийг байршуулж, улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн нийт багш нарт мэдээлэл өгч, зөвлөн туслалаа. Жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдөр буюу Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрийг тэмдэглэж, нөлөөллийн аянуудыг явуулж байна.

Мөн танхимын хичээл, сургалтын үйл ажиллагаа удаан хугацаагаар завсарласантай холбоотойгоор хүүхдэд учрах нийгэм сэтгэл зүйн байдлын хөндлөнгийн судалгааг зохион байгуулж, “Хүүхэдтэй боловсрол” 2 сарын аяныг зохион байгуулж байна. Энэ хүрээнд Эрүүл мэндийн яам, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Сургуулийн нийгмийн ажилтны нийгэмлэг, Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сантай хамтран нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 170 нийгмийн ажилтанд сэтгэл зүйн эерэг нөлөөлөл үзүүлэх сургалт зохион байгуулах, 6 телевиз, 2 сайт, “Үнэн сонин”-д мэдээлэл, ярилцлага өгч, нийтлэл-мэдээлэл гаргах, 10 мянган постер боловсруулж, сургуулиудад түгээх зэрэг нөлөөллийн ажлыг тогтмол явуулж байна.

Зургаа. Боловсролын байгууллагын багш, нийгмийн ажилтны зүгээс хүчирхийлэлд өртсөн болон өртөж болзошгүй хүүхдийг илрүүлж, хэчнээн тооны мэдээллийг аль байгууллага, албан тушаалтанд гаргасан талаарх мэдээлэл

2019-2020 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн 395,253 суралцагчаас тэднийг эрсдэлд учруулж болох хүчин зүйл, шалтгааныг тодруулах судалгааг авч, эцэг эх нь ажилгүй, орлого багатай байдаг, гэр бүлийн тогтворгүй байдал, гэр нь хөдөө, эцэг эх нь гадаадад хөдөлмөр эрхэлдэг байдал, ар гэрийн хяналт сул зэрэг нь эрсдэлт хүчин зүйл болж байгааг гаргалаа. Судалгаагаар 150,573 суралцагч /2019 оны 4 сарын байдлаар/ гэр бүлийн хүчирхийлэлд өртөж болзошгүй, гэр бүлийн хараа хяналт сул байгааг илрүүлж, анги удирдсан багшаар дамжуулан зөвлөн туслах, сургалт нөлөөллийн ажил зохион байгууллаа.

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдийг суурь боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулах журмын дагуу түр хамгаалах байр, нэг цэгийн төвөөр үйлчилгээ авсан 182 хүүхдэд ерөнхий боловсролын сургууль, албан бус насан туршийн боловсролын төвүүд боловсролын үйлчилгээ үзүүлсэн байна.



П.ЦЭДЭВСҮРЭН